

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 12 дугаар
сарын 10-ны өдөр

№ 01/23-02

Улаанбаатар хот

Глобал Монголиа Холдингс ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("Хурал")-ыг 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сонор плаза 602 тоот танхимд хуралдуулав.

Хурлын Тооллогын комиссоор Г.Хажидмаа, Ү.Ананд, Т.Отгон нар Хурал зохион байгуулах комиссоор Хан Гю Бун, С.Энхзул нар тус тус ажиллав.

Тооллогын комиссын дарга Г.Хажидмаа хурлын ирцийг танилцуулав.

2023 оны 10 сарын дугаар сарын 13-ны өдөр саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргаж хурал хуралдуулах тухай шийдвэрийг 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр гаргасан. Журмын дагуу хурал хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоногийн дараа ээлжит бус хурлыг хуралдуулах бөгөөд өнөөдөр буюу 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хуралдаж байна. Хурал хуралдуулах тухай шийдвэрийн тухай мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсэн.

Хуралдааны ирцийг танилцуулвал, компани нь 107,306 ширхэг энгийн хувьцааг гаргасан. Нийт 65,909 ширхэг хувьцааг эзэмшигч Пак Чан Су /Park Chan Soo/, Чан Кён Суг /Chang Kyoung Suk/, А.Нямдагва нар нь 2023 оны 11 сарын 25-ны өдрөөс өмнө буюу Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөс өмнө хуралд оролцох саналаа ирүүлсэн бөгөөд өнөөдрийн хуралд оролцож байна.

Нийт 64,600 ширхэг энгийн хувьцааг эзэмшигч Пак Чан Су /Park Chan Soo/, Чан Кён Суг /Chang Kyoung Suk/ нар 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Хан Гю Бун-д итгэмжлэл олгосон байна. Энэхүү итгэмжлэл нь БНСУ-д үйлдэгдсэн бөгөөд Апостиль-р баталгаажиж, 2023.11.17-ны өдөр Монгол хэлээр орчуулагдаж ирсэн байна. Тиймээс Хан Гю Бун нь хувьцаа эзэмшигч Пак Чан Су болон Чан Кён Суг нарыг төлөөлөх бүрэн эрхтэй этгээд мөн болно. Итгэмжлэлийн агуулга адил тул Пак Чан Су-с олгосон итгэмжлэлийн агуулгыг уншиж танилцуулбал:

“БНСУ-ын иргэн Пак Чан Су нь Хан Гю Бунд Глобал Монголиа Холдингс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцож шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, тэмдэглэлд гарын үсэг зурах, Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчийн бүх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгосон байна.”

Ийм учраас саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50%-иас дээш нь буюу Компанийн нийт хувьцааны 61,42%-ийн хувьцаа эзэмшигч болон хувьцаа

эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хуралд өөрийн биеэр ирсэн учир хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг мэдээлэв.

Хурлын дарга Хурлыг нээж, Хурлын дэг болон Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Хурлаар танилцуулах асуудалд:

1. Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлж, зарласан хувьцааг 1,000,000,000 ширхэгт хүргэх эсэх;
2. Нэмж хувьцаа гаргах эсэх, нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх, нэмж гаргаж буй хувьцааны үнийг тогтоох,
3. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах эсэх;
4. Гаүли ҮЦК ХХК-ийн хувьцааг худалдан авах эсэх;
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлагдаж буйтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх;

Хэлэлцэх асуудал 1. Нэмж хувьцаа гаргах замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх тухай.

Компанийн зарласан болон гаргасан энгийн хувьцааны тоо 107,306 (нэг зуун долоон мянга гурван зуун зургаа) ширхэг болно. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог 999,892,694 (есөн зуун ерэн есөн сая найман зуун ерэн хоёр мянга зургаан зуун ерэн дөрөв) ширхэгээр нэмэгдүүлж, зарласан хувьцааны тоог нийт 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэгт хүргэхээр хуралдаж байна.

Нэмж зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 1,178 (нэг мянга нэг зуун далан найм) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000,000 (нэг сая) ширхэг энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгон хаалттай хүрээнд арилжаалахаар нэмж гаргах тухай санал гаргаж байна.

Нэмж гаргах хувьцааны хаалттай хүрээнд санал болгох зах зээлийн үнийг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрөөр тасалбар болгосон хувьцааны сүүлийн 30 хоногийн жигнэсэн дундаж ханшийг үндэслэн 1,178 төгрөгөөр тогтоож байгаа.

Нэмж хувьцаа гаргах гэж байгаатай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар санал оруулж байна. Хувьцаа эзэмшигчид та бүхэн асуудал тус бүрээр саналын хуудсанд өөрийн саналыг тэмдэглэнэ үү.

А.Нямдагва: Энэ тохиолдолд компани хувьцаагаа нэмэгдүүлж байна уу, эсвэл хувьцаагаа хуваах замаар гаргах гэж байгаа билүү? Үүнийг тодруулан асуух хүсэлтэй байна.

Энэ тохиолдолд компани нь зарласан болон гаргасан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлж байгаа болно.

Хан Гю Бун: Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчид саналаа өгье. Компани нэмэлт санхүүжилт шаардлагатай байгаа тул би энэ ас уудлыг дэмжиж байна. А.Нямдагва: Хувьцаа нэмж гаргахад нэмэлт саналгүй зөвшөөрч байна.

Хэлэлцэх асуудал 2. Нэмж хувьцаа гаргах эсэх, нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх, нэмж гаргаж буй хувьцааны үнийг тогтоох тухай

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн 2018 оны 2018/01 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт “Үнэт цаас гаргагч нь хаалттай хүрээнд санал болгон хувьцаа нэмж гаргаж байгаа үед уг хугацааг худалдах үнийг тухайн хувьцааны арилжааны сүүлийн 6 сарын болон сүүлийн 30 хоногийн арилжааны жигнэсэн дундаж ханшаас 10 хувиас бага үнээр тогтоохоор шийдвэрлэсэн бол тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хувьцаа эзэмшигчдэдээ заавал олгоно” гэж заасан.

Монголын Хөрөнгийн Биржийн 2023.12.07-ны өдрийн 03/898 тоот албан бичгээр “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2023.12.06-ны өдрөөс өмнөх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш нь 1,044 /нэг мянга дөчин дөрвөн/ төгрөг байна гэж ирүүлсэн.

Мөн Монголын Хөрөнгийн Биржийн 2023.12.08-ны өдрийн 03/905 тоот албан бичгээр “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2023.12.08-ны өдрөөс өмнөх сүүлийн 30 хоногийн жигнэсэн дундаж ханш нь 1,307 /нэг мянга гурван зуун долоон/ төгрөг байна гэж ирүүлсэн.

Үүний дагуу нэмж гаргаж буй хувьцааны үнийг дээрх 2 шаардлагыг нэгэн зэрэг хангахын тулд сүүлийн 30 хоногийн жигнэсэн дундаж ханшаас 9.9%-иар хямдруулсан дүнгээр буюу 1177 төгрөгөөр тогтоох саналыг оруулж байна.

Ийнхүү, компани нь 1,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, нэг бүрийг нь 1,177 төгрөгөөр худалдснаар нийт 1,177,000,000.00 /нэг тэрбум нэг зуун далан долоон сая/ төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

Хан Гю Бун: Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчид саналаа өгье.

Хэлэлцэх асуудал 3. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах тухай.

Компанийн дүрэмд Компанийн засаглалын кодексын дагуу өөрчлөх шаардлагатай зохицуулалтууд байгаагаас гадна компани нь эрхлэх үйл ажиллагаанч чиглэлээ шинэчилж буйтай холбогдуулан компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах шаардлагатай байна.

Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар өөрчлөхөөр санал оруулж байна. Үүнд:

- ✓ Гоо сайхны бүтээгдэхүүний худалдаа

- ✓ Гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- ✓ Худалдааны зуучлал;
- ✓ Онлайн дэлгүүр;
- ✓ Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн худалдаа;
- ✓ Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ;
- ✓ Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр зөвлөгөө өгөх;
- ✓ Хоёрдогч түүхий эд боловсруулах;
- ✓ Сүлжмэл, нэхмэл эдлэлийн үйлдвэрлэл;
- ✓ Хивс, хивсэнцэр үйлдвэрлэл;
- ✓ Бэлэн хувцас үйлдвэрлэл;
- ✓ Гэрээгээр өрөмдлөгө хийх;
- ✓ Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх;
- ✓ Фермерийн аж ахуй;
- ✓ Програмын хангамжийн үйл ажиллагаа;
- ✓ Компьютерын засвар үйлчилгээ, зөвлөгөө өгөх;
- ✓ Мэдээлэл технологийн үйл ажиллагаа;
- ✓ Вэб сайтын үйлчилгээ;
- ✓ Санхүүгийн тайлан баланс бэлтгэн гаргах түүнтэй холбоотой зөвлөгөө өгөх;
- ✓ Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;
- ✓ Байгалийн ухааны эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажил;
- ✓ Зах зээлийн болон социологийн судалгаа хийх;
- ✓ Сүлжмэл, нэхмэл эдлэл, гутлын худалдаа;
- ✓ Бэлэн хувцас худалдаа;
- ✓ Хүнд машин механизмын тоног төхөөрөмжийн түрээс;
- ✓ Аялал жуулчлал;
- ✓ Бизнесийн зөвлөгөө өгөх;

Дээрх үйл ажиллагааны чиглэлүүд нь бүгд улсын бүртгэлийн байгууллагаас гаргасан тусгай зөвшөөрөл шаардлагагүй үйл ажиллагааны чиглэлүүд болно.

Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл өөрчлөх, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах асуудалд Хувьцаа эзэмшигчид саналаа өгнө үү.

Хан Гю Бун: Гуравдугаар хэлэлцэх асуудлыг мөн зөвшөөрч, цаашдын компанийн үйл ажиллагааг тогтвортой, хууль, журамд нийцүүлэн чиглүүлэн явахыг хүсье.

А.Нямдагва: Миний хувьд мөн зөвшөөрч байна.

Хэлэлцэх асуудал 4. Гаүли ҮЦК ХХК-ийн хувьцааг худалдан авах эсэх тухай.

Гаүли ҮЦК ХХК-ийн хувьцааг худалдан авах эсэх тухай асуудлыг хэлэлцье. Одоогоор энэ асуудал дээр нарийн тодорхой мэдээлэл болон шийдвэр гараагүй байгаа тул ТУЗ-д үүрэг болгон энэхүү асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг олгож байна. ТУЗ-д цаашид хуралдан хэлэлцэхийг үүрэг болгоё. Энэ асуудал дээр хувьцаа эзэмшигчид та бүхэн саналаа өгөөрэй.

Хан Гю Бун: Компанийн ТУЗ нь хуралдаж Гаүли ҮЦК ХХК-ийн хувьцааг худалдан авах эсэх тухай асуудлыг хэлэлцэхийг миний бие дэмжин, зөвшөөрч байна.

А.Нямдагва: Миний хувьд мөн зөвшөөрч байна.

Хэлэлцэх асуудал 5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлагдаж буйтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх.

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлагдаж буйтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай асуудалд хувьцаа эзэмшигчид та бүхэн саналаа өгнө үү.

Хан Гю Бун: хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй болохыг зөвшөөрч байна.

А.Нямдагва: Миний хувьд мөн зөвшөөрч байна. Шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг нэг бүрийг компани 1,177 төгрөгөөр худалдаж авахаар ойлгож байгаа.

Тооллогын комиссын дарга Г.Хажидмаа: 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлуудын саналын дүнг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 1: “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлж, зарласан хувьцааг 1,000,000,000 ширхэгт хүргэх эсэх тухай асуудал Компанийн хувьцаа эзэмшигчдийн 61,42%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 2: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 61,42%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 3: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 61,42%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 4: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 61,42%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.


Хэлэлцэх асуудал 5: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 61,42%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.

Хурлын дарга: “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлуудыг бүрэн хэлэлцэж дууслаа. Ингээд өнөөдрийн хурлыг хаасныг мэдэгдэж байна.


Хурлын дарга Хурлыг 10:48 минутад хаав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ


ХАН ГЮ БУН

/Хувьцаа эзэмшигч Park
Chansoo (Пак Чан Су)-г
төлөөлж/



ХАН ГЮ БУН

/Хувьцаа эзэмшигч Chang
Kyoungsuk (Чанг Кён Сук)-
г төлөөлж/


А.НЯМДАГВА

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:





Г.ХАЖИДМАА